



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2025 оны 01 сарын 14 өдөр

Дугаар А/05

Хэрлэн сум

Тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3, Зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3, 8 дугаар зүйлийн 8.1.13, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комиссын 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Бор-Өндөр суманд үйл ажиллагаа явуулах “Суу Гоодаль” ХХК-ийн II зэрэглэлийн эмийн сан, Дархан суманд үйл ажиллагаа явуулах “Их Мандал” ХХК-ийн II зэрэглэлийн эмийн санд тус тус 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрөөс 3 жилийн хугацаатай олгосугай.

2. Дээрх байгууллагуудын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, мэргэжил аргазүйн зөвлөгөө өгч ажиллахыг Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга (Х.Доржханд), Эмийн бодлого, чанар, аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн (О.Энх-Уянга) нарт даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтсийн дарга (Д.Наранмичид)-д үүрэг болгосугай.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.ЭНХБОЛОР

